

Н.ГАНТУЛГА

Хууль сахиулах их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүй доктор, дэд профессор, хурандаа

АВИЛГЫН СЭТГЭЛ ЗҮЙН ҮНДЭС

Хээл хахуул авах нь авилгын хамгийн эртний хэлбэр гэж үзэж болно. Авилгын шинжтэй эрх зүйн зөрчлүүдийн нэг гол үндэс-нөхцөл нь нийгмийн бүлгийн хүрээнд тогтсон зарим сөрөг зан үйл-тодорхой хэм хэмжээ байдаг. Тухайлбал: Нийтэд албан ёсоор зарлаагүй боловч авилгачдын хүрээлэлд хүлээн зөвшөөрөгдсөн “хахууль авсан бол удирдлагатайгаа хуваалц” гэсэн ахуйн сэтгэлгээ-дэг ёс үүнд юуны өмнө хамаарна. Иймээс авилгачдын зүгээс хээл хахууль, авилгын шинж чанартай нэгж тохиолдол, нийт үзэгдэлд хандах зан суртахуун /ёс зүй/ нь хууль ёсыг даган биелүүлэгч төрийн албан хаагчдынхаас эрс ялгардаг.

Судлаачдын үзэж байгаагаар авилгын сэтгэл зүйн үндэс-нөхцөл нь тэдний ухамсар-ахуйд бүрэлдэн тогтсон өөрсдийгөө хамгаалах сэтгэл зүйн механизм мөн. Тодруулбал авилгачдад өөрсдийн гэмт зан үйлийг өмөөрөн зөвтгөдөг дараах 5 сэдэл-учир шалтгаан байдаг талаар бүтээлүүдэд тэмдэглэжээ. Энэ нь:

1. **“Хариуцлагыг үгүйсгэх сэтгэл зүй”.** Авилгач этгээд өөрийгөө авилгын субъект гэхээсээ илүү энэ үйл ажиллагаа-үйл явдлын объект гэж тооцдог. Учир нь тэдний

үзэж байгаагаар авилга авагч /зайлшгүй/ нөхцөл байдлын “золиос” болдог.

2. **“Гэм хорыг үгүйсгэх сэтгэл зүй”.** Хахууль авсан албан тушаалтан өөрийн үйл ажиллагаанд гэм хор байхгүй гэж үздэг. Түүний хувьд хахууль авсан явдал нь тодорхой этгээдэд хамааралтай зөв /ур ашигтай/ шийдвэр гаргасан үйл ажиллагааных нь хариу “талархал” гэж тооцогддог.

3. **“Хахуульд хохирогч /золиос/ байхгүй хэмээх сэтгэл зүй”.** Хахууль өгөгч нь шударга бус замаар олсон мөнгөнийхөө тодорхой хэсгийг л өгч байгаа тул түүнийг авсан албан тушаалтан хэнд ч хор хохирол учруулдаггүй. Иймээс авилгачдын хувьд хахууль өгөгч өөрөө эрх зүйн зөрчил гаргагч /хулгайч, татвараас зайлсхийгч, залилан мэхлэгч/ этгээд мөн.

4. **“Авилгыг эсэргүүцэгчдийг буруутгах сэтгэл зүй”.** Тэд “хүн бүр хахууль авдаг” гэсэн үзэл хандлагатай ба үүнийгээ хамт ажиллаж буй зарим алба хаагч, дарга нарынхаа жишээгээр тайлбарладаг. Өөрөөр хэлбэл зөвхөн цалингаараа тэд амьдарч, одоогийн албан тушаал, орон байр, бусад орчин, хамгамжаа бий болгосон гэвэл ташаа болно гэж төсөөлөдөг.

5. **“Ийнхүү нийгмийн ахуйд бүрэлдсэн дээрх дэг, ёс зүйн хэм хэмжээ, сэтгэл зүйн орчинд ёс суртахууны ариун нандин үнэлээмж, үзлүүд уусч, саармагжсан**




Угийсгэгдэг ба олон нийтийн /тодорхой бүлгийн/ үзэл хандлагатай авилгач-дарга нарын үйл ажиллагаа ийнхүү зохицон оршдог гэж энэ хүрээлэлд тайлбарлагддаг.

Иймээс алба хаагчаас өгсөн хахуулиас дарга татгалзах нь тэднийг барьж өгнө, тэдэнд итгэхгүй байна гэсэн ташаа ойлголт, сэтгэл зүйн орчинг бичил хамт олны хүрээнд бий болгох, мөн тогтсон дэг ёс, уур амьсгалыг эвдэх зэрэг сөрөг нөлөөлөлтэй гэж авилгачид гэмт зан үйлээ зөвтгөдөг байх магадлалтай.

**N.ГАНТУЛГА**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

**N.БАТДОРЖ**

Ахлагчийн сургуулийн ахлах багши, хууль зүйн магистр, хошууч


ФРАНЦЫН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ (ПЕНИТЕНЦИАР) ТОГТОЛЦОО

Нэг. Удирдтгал

Албан ёсоор Бүгд Найрамдах Франц Улс хэмээн нэрлэгддэг Франц улс орнөд Европт оршдог. Европ дахь ундысэн орноос гадна далайн чанад газар нутагтай. Францын ундысэн орон өмнө зүгийн Газрын дундад тэнгисээс, умар зүгт La-Манийн хоолой, Умард тэнгис, дорно зүгийн Рейн мөрнөөс өрнө зүгийн Атлантын далај хүрнэ.

Францууд эх орноо геометрийн дүрсээс нь шалгаалж L'Hexagone буюу "б өнцөгт" хэмээн нэрлэх нь олонтаа.

Франц нь хагас-ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх




болон шүүх засаглал нь нэгдмэл. Нийслэл нь Парис хот.

Эх газрын Франц нь Бельги, Люксембург, Герман, Швейцари, Итали, Монако, Андорра, Испани улсуудтай хиллэдэг. Мөн Францын газар нутаг болох Франц Гвиана нь Бразил, Суринам улсуудтай, Сэнт-Мартин нь Нидерландын Антилийн арлуудтай тус тус хил залгана. Ла-Манийн хоолой доорх Чаннель туннелаар (Channel Tunnel) Британийн залгадаг.

17-р зууны сүүл үеэс 19-р зууны эхэн үе хүртэл Франц нь дэлхийн хамгийн хүчирхэг орнуудын тоонд тооцогдох байв. Франц өндөр хөгжилтэй орон бөгөөд эдийн засаг нь номинал ҮНБ-р дэлхийд зургаад, худалдан авах чадварын паритетаар тооцсон ҮНБ-ээр наймд жагсдаг..

Тэрээр Европын холбоог анх байгуулсан орнуудын



нэг, гишиг орнуудаас хамгийн их нутаг дэвсгэртэй. Мөн ҮНБ-ыг байгуулсан анхдагч орнуудын нэг ба ҮНБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишиг, цөмийн зэвсэгтэй орон юм.

Хоёр. Ял эдлүүлэх тогтолцооны зохион байгуулалтын бүтэц

2013 оны 07-р сарын 01-ний байдлаар энэ улсын Хууль зүйн яамны харьяа ял эдлүүлэх захиргааны бүрэлдэхүүнд түүний харьяа ял эдлүүлэх байгууллага, дахин нийгэмшүүлэх ба ял эдлүүлэх пробацийн¹ албадын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий 9 бүс дундын газар, 1 усан талбай бүхий нутаг дэвсгэрийг хариуцсан захиргаа байна.

Хорих дэглэм болон ялтны бүрэлдэхүүнээс хамаараад ял эдлүүлэх байгууллагын хэд хэдэн төрөл бий. Франц улсад ял эдлүүлэх 192 байгууллага үйл


¹ Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх

ажиллагаагаа явуулдаг ба тэдгээрийг а/ Мөрдөн тусгаарлах газар², б/ Ял эдлүүлэх байгууллага гэсэн 2 хэсэгт хувааж болно.

Мөрдөн тусгаарлах газрууд: Энэ төрлийн 99 газар бий ба тэдгээрт нийтээс тусгаарлагдан мөрдөн шалгагдаж шүүх хуралдааныг, мөн шүүхийн шийтгэх тогтоол хүчинтэй болох хугацааг хүлээж буй гэмт хэрэгтнүүд, 2 хүртэлх жилийн хорих ялтай (эсвэл хорих ялын үлдсэн ийм хугацаатай) ялтнууд хоригддог.

Ял эдлүүлэх байгууллагууд: Нийтдээ энэ төрлийн 85 байгууллага бий ба үүнээс төв хорих газар (шорон) -6, хорих төвүүд-25, хагас эрх чөлөөтэй дэглэм бүхий төв-11 болно. Мөн 43 ял эдлүүлэх төвүүд байдаг ба тэдгээрийн бүтцэд мөрдөн тусгаарлах газар, хорих төв/төв хорих газрууд байж болдог. Түүнчлэн 2007 оны 06 дугаар сараас 2008 оны 04-р сарын хооронд насанд хүрээгүйчүүдийн ял эдлэх 6 тусгай байгууллага нээгдсэн.

Төв хорих газрууд (шорон)-д урт



хугацааны хорих ялтай болон нийгэмд ихээхэн аюул занал бүхий хүмүүс ял эдэлдэг. Иймд дэглэм нь юуны өмнө аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг.

² Манай улсын жишээн дээр адилтган үзвэл энэ нь Цагдан хорих байр болно.

Хорих төвүүдэд их бус буюу 2,




түүнээс дээш жилийн хорих ялтай, засрал хүмүүжилээ олж дахин нийгэмших боломжтой хоригдлууд ял эдэлдэг. Иймээс дэглэм нь юуны өмнө хоригдлыг дахин нийгэмшүүлэх үйл ажиллагаа ажиллагаанд захирагддаг.

Хагас эрх чөлөөтэй дэглэм бухий төвүүд нь ял эдлүүлэх байгууллагын байрны гадна амьдрахыг зөвшөөрсөн болон эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарласан ялтнуудыг хүлээн авдаг. Энэ төрлийн хорих ял эдлэгсэд өдрийн цагаар мэргэжлийн үйл ажиллагаа (ажил хийх) явуулах, боловсрол, мэргэжлийн сургалтуудад хамрагдах, эмчилгээ хийлгэх болон бусад ажил-арга хэмжээнд оролцох зорилгоор ял эдлүүлэх байгууллагын байрнаас гадагшаа явах эрхтэй. Энэ бүхэн мөн л ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд юуны өмнө чиглэгддэг.

Ноогдуулсан ял нь илүү хөнгөн ялаар солигдсон этгээдүүдийн ял эдлэх төв (хэсэг)-д эрх чөлөө нь хэсэгчилэн хязгаарлагдсан дэглэмтэй; ял эдлүүлэх байгууллагын гадна амьдрахыг зөвшөөрсөн; нэг жилээс бага хорих ялын хугацаатай ялтнуудыг хүлээн авдаг ба гол үүрэг нь ялтнуудыг дахин нийгэмшүүлэх хөтөлбөрүүдэд хамруулахад чиглэгддэг.

Дахин нийгэмшүүлэх ба ял эдлүүлэх пробацийн албад: Францад ийм төрлийн 103 алба бий. Тэд засаг захиргааны нэгжийн эрх мэдэл-харьяалалд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ албад шүүх засаглалын удирдлага дор хоригоос бусад (альтернатив)



төрлийн ял эдлүүлэх явдлыг, түүнчлэн мөрдөн шалгагдаж буй болон ял оноогдсон этгээдүүдийн шүүхийн өмнөх болон шүүхийн дараах процессын зарим төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Эдгээр албадын гол үүрэг нь шүүн таслах үйл ажиллагааны хугацаанд тусlamж үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг нь таслан зогсоох, оногдуулсан ялыг биечлэн /ганцаарчилан/ эдлүүлэх, дахин нийгэмшүүлэх болон хяналт тогтоосон хүмүүсийн үйл ажиллагаанд мониторинг, шалгалт хийх явдал юм.

Гурав. Тоо баримт ба үйл явдал

Энэ улсын хорих газруудад 2013 оны 05-р сарын 01-ны байдлаар 67.839 хүн, түүнээс мөрдөн хоригдож буй-16.987, хорих ял эдлэж буй 50.852 хүн байна. Хорих ял эдлэгсдээс 2041 хүн хагас эрх чөлөөтэй нөхцөлд, 435 хүн хорих байгууллагын гадна амьдрах эрхтэй нөхцөлд ял эдэлж байна.

Хоригоос өөр төрлийн ялыг цахим бугуйвч ашигласан хяналт дор 10.760 хүн, мөн ял эдэлсэн хугацаа дууссан боловч

цахим бугуйвчийг зүүж хяналтад хамрагдаж буй 678 хүн байна.

2207 хоригдогч эмэгтэй байгаа ба Үүнээс мөрдөн хоригдож буй нь 678. Насанд хүрээгүй 771 хүн хоригдож буй ба үүний 477 нь мөрдөн хоригдогсод.

Энэ улсын хорих газрууд 57.235 хүнийг багтаах хүчин чадалтай ба өнөөгийн байдлаар 8 хорих газрын хувьд 200 ба түүнээс дээш хувийн, 33 газар 150-200%, 58 газар 120-150%, 33 газар 100-120%, 117 газар 100 ба түүнээс бага хувийн дүүргэлттэй байна.

Хорих газруудад 2447 эмнэлгийн ажилтан ажиллагадаг ба тэд Эрүүлийг хамгаалах яаманд харьяалагддаг. Энд эмнэлгийн-178 хэсэг, засаг захиргааны нэгж хоорондын-7 эмнэлэг, үндэсний хэмжээний “Френь” хориход байрлах - хорихын 1 госпитал, эмнэлэг-сэтгэл зүйн засаг захиргааны нэгжийн - 26 лаборатори бий. Хорих байгууллагуудын хэмжээнд 152 сэтгэл зүйч-эмч ажилладаг.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар 100 мянган хүн аманд ногдох энэ улсын хоригдлын тоо нь 99,1 хүн байсан.

2011 онд хорих ял эдлэгсийн дундаж хугацаа нь 9,6 сар байсан. Нийт ял эдлэгсийн дунд 5 ба түүнээс дээш жилийн хорих ялаар шийтгэгдсэн 1,9 %, 1 жил ба түүнээс бага хугацаатай нь 81.5%, нэг сар ба түүнээс бага хугацаатай нь 13,3% тус тус болно. Мөн бүх насаараа хорих ялтай 487 хүн байна.

Ял эдлэгсийн дундаж нас 34,4. Ял эдлэгсийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл: 26,5% нь хүчирхийлийн санаатай үйлдэл; 13,4% нь хүчин болон сексийн шинж чанартай хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, эсвэл тэдгээрийг хийхийг завдсан; 6% нь бусдыг санаатай алсан, 11,3% нь тусгай

бүрэлдэхүүнтэй хулгайн гэмт хэрэг, 7,8% нь эдийн засгийн, 14,2% нь хар тамхи мансууруулах бодисын хууль бус үйл ажиллагаатай холбогдсон гэмт хэрэг үйлдэгчид байна.

Ял эдлэгсийн 82,4% нь францын, 17,6% нь гадаадын иргэн байна.

2011 онд 57.629 удаагийн богино хугацаагаар хорих газраас гарах зөвшөөрлийг олгосны гадна 7481 хүн хугацаанаасаа өмнө суллагджээ.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар дахин нийгэмшүүлэх болон пробацийн албаны хяналтанд³ 173.063 хүн ял эдэлж, үүнийг 4080 албан хаагч хянаж байжээ.

2011 онд энэ орны хорих газруудад: орголт -4 /2010 онд 7/; бусдыг барьцаанд авсан -7 /2010 онд 2/; нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын -667 удаагийн тохиолдол /2010 онд 761/; албан хаагчдад хүч хэрэглэсэн -4083 /2010 онд 30230/; бусад хоригдолд хүч хэрэглэсэн тохиолдол -8,365 /2010 онд 7825/; хүн амины -3 /2010 онд -4/ гэмт хэрэг үйлдэгджээ.

2011 онд 116 ялтан амиа хорлосон талаар бүртгэгдсэн ба энэ нь 10.000 ялтантай харьцуулахад 17,1 хувийг эзэлж байсан. Мөн 1932 амиа хорлох оролдлого бүртгэгдсэн.

2011 онд 24.934 хоригдогсод цалинтай ажлаар хангагдсан (60.304.105 европийн цалин авсан) ба энэ нь нийт хоригдогсдын 39,1% болно.

25,437 хоригдогсод мэргэжлийн бэлтгэлийн төрөл бүрийн дамжаанд, 46,186 насанд хүрсэн хорих ял эдлэгсэд анхан шатнаас дээд боловсрол олгох сургалтуудад хамрагджээ.

Францын хорих байгууллагуудад 2011 онд рецидив гэмт хэрэгтэй тэмцэхэд

³ “Хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх албаны” хэмээн өөрөөр нэрлэж болно.

чиглэгдсэн 190 орчим төрөл бүрийн хөтөлбөрүүд хэрэгжсэн.

Мөн энэ онд албан хаагчдаас 300 гаруй мэргэжлийн дасгалжуулагчид хоригдогсдын биеийн тамир спортын бэлтгэлийг удирдан явуулжээ.

2011 онд төрөл бүрийн шашины 1.249 төлөөлөгч (үүнээс 397 нь орон тооны ажилтны хувиар) хоригдогсодтой ажилласан ба тэдгээрийн 665 нь католик, 317 нь протестант, 151 нь мусульман, 70 нь иудеи, 24 нь үнэн алдартны, 32 нь шашны бусад урсгалд хамаарч байна.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар энэ улсын хорих байгууллагууд 35,420 албан хаагчтай ба тэдгээрээс: удирдах ажилтанд-503, хяналт-харуул хамгаалалтын ажилтанд-26.094, дахин нийгэмшүүлэх ба пробацийн (хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх) албанд-4080, захиргааны ажилд-2811, техникийн үйлчилгээнд-602, бусад үйл ажиллагаанд-1330 хүн хамаарч байна. Шуурхай ажиллагаа, аюулгүй байдлын хэсэгт (хорихын тусгай зориулалт бүхий бүлэгт) 377 алба хаагч ажилладаг.

Францын хорихын захиргааны Үндэсний сургуульд 2011 онд 3467 хүн сургалтад хамрагдсан.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар сард: хяналтын үүрэг гүйцэтгэгч бага (жирийн) албан тушаалтан 1447 (алба хааж буй эхний жил)-2072 евро, хорих байгууллагын дэслэгч 1752-2731 евро, ахмад 2277-3004 евро, захиргааны зөвлөх 3377-4963 евро, хорих байгууллагын дарга 2168-4638 евро, дахин нийгэмшүүлэх ба пробацийн албаны зөвлөх 1645-2917 евро, инженер техникийн ажилтан 1670-2575 еврогийн цалин авч байжээ.

2012 оны хорих байгууллагын нийт төсөв 2,39 тэрбум еврогоос бүрдэж байсан

ба үүний 52% нь албан хаагчдад зарцуулагджээ.

2011 онд шинэ алба хаагчдыг энэ албанад авахад чиглэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өргөн оролцоо бүхий үндэсний хэмжээний компанийт ажил зохион байгуулагдсан ба 610 сул орон тоон дээр 22898 хүний өргөдлийг хүлээн авсан байна.

Дөрөв. Хорих байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо

Францад бусад иргэдийн адил түвшинд хоригдлын суурь эрхүүд хамгаалагдсан байдаг. Хорих байгууллагын захиргаа өөрийн чиг үүргийг Хүний болон иргэний эрхийн тунхаглал, Францын Үндсэн



хууль, 2009 оны 11-р сарын 24-ний өдрийн Ял эдлүүлэх /Пенитенциарный закон/ хууль болон хүний эрхийг хамгаалах олон улсын конвенцуудад нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мөн захиргаа үйл ажиллагаандаа хүний халдашгүй байдал, нэр алдарт нь хүндэтгэлтэй хандах үүрэгтэй. Түүнчлэн хорих байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын дэг журам /процедур/ нь Францын эрүүгийн процессын болон бусад хуулиудад тусгагджээ.

Өнөөдөр энэ улсын хорих байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг дараах байгууллагууд байна. Энэ нь:

1. Захиргааны болон шүүх эрх мэдлийн байгууллага, парламентаас корпусаас явуулах байнгын болон цаг үеийн хяналт.

Хорих газрууд нь төрийн байгууллагуудын хяналтын объект байдаг. Үүнд дотоод хяналтыг хорих байгууллагын мэргэжлийн албад, гадаад хяналтыг Хөдөлмөрийн хяналт шалгалтын газар⁴, Эрүүлийг хамгаалахын Ерөнхий хяналт шалгалтын⁵ болон бусад газрууд хэрэгжүүлдэг. Мөн шүүх засаглалын хяналтыг ял шийтгэлийг хэрэглэх шүүгч, мөрдөн хорих үйл ажиллагаанд хяналт тавих шүүгч, мөрдөн хорих танхимын ерөнхийлөгч, прокурор, ерөнхий прокурор хэрэгжүүлдэг. Парламентын Нийтийн танхимын депутатууд, Дээд танхимын сенаторууд, тэрчлэн Франц улсаас сонгогдсон Европын Холбооны парламентын гишүүд ямар ч цаг хугацаанд хорих байгууллагад очиж үйл ажиллагаатай нь танилцах, хоригдуудтай чагнах, тагнах явдлаас ангид ганцаарчилан уулзах эрхтэй.


2. Хөгжлийн зөвлөл

2009 оны 11-р сарын 24-ны өдрийн Ял эдлүүлэх хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Хяналтын комиссууд нь Хөгжлийн асуудал хариуцсан зөвлөлүүд болон өөрчлөгдсөн. Энэ зөвлөл хорих байгууллага бүрт байрлаж түүний

үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг ажиглан, сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг санал болгох бүрэн эрхтэй. Ялангуяа энэ зөвлөл хорих байгууллагын зүгээс хоригдогсдын эрх, аюулгүй байдлыг сахиж буй байдал, эмнэлгийн үйлчилгээ, дахин гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх болон ял шийтгэлийг хөнгөн төрөл болгон солиход чиглэгдсэн ажил-арга хэмжээнд ажиглалт хийдэг.

Хөгжлийн зөвлөлийг тухайн хорих байгууллага байрлаж буй засаг захиргааны нэгжийн дарга⁶ /эсвэл түүний орлогч/ тэргүүлдэг ба түүнд засаг захиргааны нэгжийн нэр хүнд бүхий алба хаагчид /өмгөөлөгчид, хотын дарга, магистратууд⁷/, тэрчлэн төрөл бүрийн байгууллагын төлөөлөгчид /төрийн бус байгууллага, нэгдлүүд, шашны зүтгэлтнүүд/-ээс бүрддэг. Энэ зөвлөл жилд 1-ээс цөөнгүй удаа цугладаг бөгөөд хуралдааныхаа үр дүнгээр илтгэл бичиж хууль зүйн сайдад илгээдэг.

3. Хүний эрхийн бүрэн эрхт



төлөөлөгч /түүний төлөөлөл/

Хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгч нь төрийн байгууллага, албан тушаалтын

⁴ Инспекция труда /Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллага/

⁵ Генеральная инспекция здравоохранения

⁶ Префект

⁷ Шүүх, прокурорын болон засаг захиргааны албан тушаалтнууд ингэж нэрлэгддэг.

Үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг сахин хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих үүрэг бүхий хараат бус албан тушаалтан юм. Түүний үндсэн үүрэг-зорилгод хэний боловч эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа ялгаваргүй байдал, хуулийн өмнө эрх тэгш байх явдлыг хамгаалах явдал болно. Тэрээр мөн аюулгүй байдлыг хангах салбарт мэргэжлийн ёс зүйг сахиулах Үндэсний комиссын үйл ажиллагаанд оролцдог. Хүний эрхийн бүрэн



эрхт төлөөлөгч /мөн түүний төлөөлөл/ нь ялангуяа иргэд ба төрийн эсвэл захиргааны байгууллага хоорондын зөрчилдөөнт нөхцөл байдлуудыг эв зүйгээр шийдвэрлэх, зохицуулахад оролцдог. Хоригдогсод⁸ хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгчид захидал илгээх замаар шууд харьцах эрхтэй ба захидал нь ямар нэгэн хяналт шалгалтаас гадуур үнэ төлбөргүй илгээгддэг.

4. Албадан хорих газруудын Ерөнхий хянан байцаагч

Энэ албан тушаал нь 2007 оны 10-р сарын 30-ны хуулиар бий болсон. Албадан хорих газруудын Ерөнхий хянан байцаагч нь хорих ял эдлэх нөхцөл, хорих ял эдлэгсдийн шилжилт хөдөлгөөн болон тэдний эрхийг сахиж буй байдалд хяналт шалгалт явуулах

эрхтэй. Энэ албан тушаалтан үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүднээс орон тооны хянан байцаагч нарыг захиргаандаа авч ажлуулдаг. Тэд ямар ч үед ял эдлүүлэх байгууллагад орох, чагнах, тагнах явдлаас ангид ял эдлэгсэд, бусадтай уулзах эрхтэй.

Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд (нэгдэл, төрийн бус байгууллагууд), түүнчлэн хувь хүн Ерөнхий хянан байцаагчид хоригдогсодын эрх зөрчигдөж буй аливаа баримтыг мэдээлэх эрхтэй. Харин холбогдох хяналт шалгалтыг явуулсны дараа Ерөнхий хянан байцаагч төрийн засаглалын зохих байгууллагад өөрийн сануулгыг хүргүүлэх эрхтэй ба тэрээр тогтоосон хугацаанд хариултыг өгөх үүрэгтэй. Түүнчлэн Ерөнхий хянан байцаагч гэмт хэрэг үйлдсэн нь түүнд илэрхий болсон баримтыг прокурорт мэдээллэх үүрэгтэй.

Ерөнхий хянан байцаагч нь аливаа зөвлөгөө, зөвлөмжийг өгөх, хууль, хууль тогтоомжийн бусад актуудад нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргах эрхтэй ба өөрийн үйл ажиллагааны жил бүрийн тайланг нийтэд хэвлэн мэдээллэх үүрэгтэй.

5. Эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар, нэр алдарыг нь гутаан харьцах,



COUNCIL
OF EUROPE

CONSEIL
DE L'EUROPE

⁸ Мөрдөн шалгагдаж байгаа болон ял эдлэгсэд